

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 26 өдөр

Дугаар: 12

Улаанбаатар хот

**Компанийн зохион байгуулалтын  
бүтэц, орон тооны хязгаарыг  
шинэчлэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.4.4.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн зохион байгуулалтын бүтцийг 1 дүгээр, орон тооны хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан компанийн хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” 21 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ